



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Булган сумын Нэгдсэн эмнэлэгийн 2022 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/33/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: Ц.Бадрал
Утас: 91983443
цахим хаяг: Badralts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.5.1 Төсвийн төлөвлөлт	16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	16
3.5.3 Нэмэлт төсөв	17
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.4.2 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.4.3 Завсрын аудитын талаар	19
4.4.4 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Залруулсан алдаа	20
5.2 Төлбөрийн акт	20
5.3 Албан шаардлага	20
5.4 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЙМГИЙН БУЛГАН
СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛЭГИЙН
ДАРГА Б.ТҮМЭНБАЯР ТАНАА

2023.02.02 № 02/08

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Булган сумын нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Булган сумын нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт бараа материалтай холбоотой 11.0 сая төгрөгийн мах, 102.6 сая төгрөгийн нүүрс биетээр оршин байхгүй хуулийн байгууллагад шалгагдаж байна. Мөн 82.4 сая төгрөгийн эм боох материалын үлдэгдэл бодитоор оршин байхгүй, урьд онуудын тайланд буруу тусган үлдэгдэл зөрсөн асуудал шийдвэрлэгдээгүй байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор гол асуудал нь тайлант онд өмнөх оны эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн авлага болох 166.8 сая төгрөгийн авлагыг барагдуулж эм, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрүүдийг барагдуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

2022 онд амбулаторийн үзлэг 29861, урьдчилан сэргийлэх үзлэг 1282, идэвхтэй хяналтыг 2199, гэрийн эргэлтийг 917, гэрийн дуудлага 1639 хүнд тус тус хийсэн байна. Түргэн тусламжийн 246 дуудлагад хүрч үйлчилснээс ойрын дуудлага-79, алсын дуудлага 167 байна. Эмнэлэгт 2017 хүн хэвтэн эмчлүүлж 16107 ор хоног ашигласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	466,253,646.92	318,322,942.43
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,472.33	1,045,423.80
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,472.33	1,045,423.80
3121	Төгрөг	4,472.33	1,045,423.80
31211	Төрийн сангийн харилцах	4,472.33	1,045,423.80
33	АВЛАГА	194,282,054.00	11,963,898.54
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	12,319,013.00	7,123,803.04
332	Төлбөртэй үйлчилгээний авлага	166,830,311.00	0.5
335	Бусад авлага	15,132,730.00	4,840,095.00
3351	Байгууллагаас авах авлага	11,170,535.00	877,900.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,962,195.00	3,962,195.00
35	БАРАА МАТЕРИАЛ	271,967,120.59	305,313,620.09
351	Түүхий эд материал	110,496,688.95	149,651,838.25
3511	Тусгай зориулалттай материал	9,793,478.00	13,352,578.00
3513	Эм боох материал	100,703,210.95	136,299,260.25
354	Хангамжийн материал	161,470,431.64	155,661,781.84
3541	Бичиг хэргийн материал	1,552,750.00	1,701,000.00
3542	Аж ахуйн материал	9,710,560.00	4,460,700.00
3544	Түлш, шатах тослох материал	125,410,958.00	123,551,518.20
3546	Хүнсний материал	16,363,440.00	17,515,840.00
3547	Бусад хангамжийн материал	8,432,723.64	8,432,723.64
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,392,786,797.80	7,431,744,963.13
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,392,786,797.80	7,431,744,963.13
392	Биет хөрөнгө	7,378,293,214.45	7,417,876,379.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,240,172,123.00	7,236,933,339.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-529,529,265.00	-701,157,217.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	135,449,054.00	207,590,495.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-129,937,481.76	-129,138,101.80
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,336,023,407.36	1,547,902,671.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	-684,795,531.96	-773,187,087.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	70,904,087.00	54,243,360.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-59,993,178.19	-45,311,079.58
39214	Бусад үндсэн хөрөнгө		20,000,000.00
393	Биет бус хөрөнгө	14,493,583.35	13,868,583.39
39301	Программ хангамж	1,525,000.00	1,525,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-535,416.65	-1,160,416.61
39303	Бусад биет бус хөрөнгө	13,504,000.00	13,504,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,859,040,444.72	7,750,067,905.56
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	245,975,672.80	19,905,578.73
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	245,975,672.80	19,905,578.73
413	Өглөг	245,975,672.80	19,905,578.73
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	91,182,329.12	15,757,188.15
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	149,209,089.92	2,803,875.82

4136	Бусад өглөг	5,584,253.76	1,344,514.76
41361	Байгууллагад төлөх өглөг	4,407,830.76	774,980.76
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,176,423.00	569,534.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,613,064,771.92	7,730,162,326.83
51	Засгийн газрын хувь оролцоо	7,613,064,771.92	7,730,162,326.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	470,965,819.00	470,965,819.00
51101	Өмч: - төрийн	470,965,819.00	470,965,819.00
512	Хуримтлагдсан үр дүн	6,957,800,705.55	7,080,501,709.46
5121	Өмнөх үеийн үр дүн	6,957,800,705.55	6,963,404,154.55
5122	Тайлант үеийн үр дүн		117,097,554.91
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	184,298,247.37	178,694,798.37
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,859,040,444.72	7,750,067,905.56

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,187,383,676.90	2,295,177,248.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	394,900,087.40	350,228,623.00
120	Нийтлэг татварын бус орлого	394,900,087.40	350,228,623.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	341,097,573.36	49,564,952.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	28,577,452.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,423,874.00	987,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	321,673,699.36	20,000,000.00
120009	Бусад орлого	2,000,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	300,663,671.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	51,802,514.04	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,792,483,589.50	1,944,948,625.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	238,306,660.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	238,306,660.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	96,967,605.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	96,967,605.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,457,209,324.50	1,944,948,625.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	80,969.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,457,209,324.50	1,944,867,656.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,149,263,169.60	2,177,826,568.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,149,263,169.60	2,177,826,568.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,060,663,169.60	2,177,826,568.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,098,611,156.46	1,139,371,417.80
210101	Үндсэн цалин	550,423,286.18	689,208,471.31
210102	Нэмэгдэл	393,413,517.16	322,692,266.55

210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,912,000.60	19,367,000.00
210104	Урамшуулал	117,862,352.52	108,103,679.94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	142,170,583.92	144,503,934.00
210201	Тэтгэврийн даатгал	87,791,244.99	98,952,146.70
210202	Тэтгэмжийн даатгал	23,004,902.13	11,387,947.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,396,622.97	9,110,357.41
210204	Ажилгүйдлийн даатгал	1,926,744.41	2,277,589.57
210205	Эрүүл мэндийн даатгал	21,051,069.42	22,775,893.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	73,983,935.20	71,467,556.50
210301	Гэрэл, цахилгаан	25,375,935.20	23,458,026.50
210302	Түлш, халаалт	43,508,000.00	40,694,530.00
210303	Цэвэр, бохир ус	5,100,000.00	7,315,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	92,375,290.62	112,467,696.66
210401	Бичиг хэрэг	7,129,450.00	32,771,360.00
210402	Тээвэр, шатахуун	51,515,020.00	57,315,704.80
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,249,600.62	8,873,986.10
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	420,000.00	6,639,319.34
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,061,220.00	1,944,592.42
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	4,922,734.00
2105	Нормативт зардал	388,354,739.20	371,365,187.26
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	337,362,707.20	310,542,907.26
210502	Хоол, хүнс	50,992,032.00	56,419,280.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	4,403,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,311,800.00	15,654,382.80
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,407,000.00	7,810,100.00
210604	Урсгал засвар	1,904,800.00	7,844,282.80
2107	Томилолт, зочны зардал	1,515,000.00	9,834,150.00
210702	Дотоод албан томилолт	780,000.00	9,834,150.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	735,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,288,850.00	9,253,362.40
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,040,000.00	4,621,187.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	428,850.00	1,228,020.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	296,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	606,427.20
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,700,000.00	2,439,000.00
210807	Газрын төлбөр		62,528.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	244,051,814.20	303,908,880.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,900.00	3,757,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		879,500.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	244,009,914.20	299,272,380.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,600,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	88,600,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	88,600,000.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	38,120,507.30	117,350,679.91
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	253,125.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	253,125.00
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-253,125.00
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	38,120,507.30	117,097,554.91

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,647,091,476.50	2,142,130,708.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,423,874.00	30,167,862.00
120	Нийтлэг татварын бус орлого	21,423,874.00	30,167,862.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,423,874.00	30,167,862.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		28,577,452.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,423,874.00	1,590,410.00
120009	Бусад орлого	2,000,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,625,667,602.50	2,111,962,846.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	238,306,660.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	238,306,660.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	96,967,605.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	96,967,605.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,290,393,337.50	2,111,962,846.50
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	14,323.00	264,880.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,290,379,014.50	2,111,697,966.50
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,643,073,404.17	2,123,269,757.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,643,073,404.17	2,123,269,757.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,554,473,404.17	2,123,269,757.03

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,043,715,421.17	1,177,177,201.28
210101	Үндсэн цалин	516,979,757.85	651,155,823.93
210102	Нэмэгдэл	387,135,689.74	405,493,269.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,737,220.60	15,380,460.28
210104	Урамшуулал	108,862,752.98	105,147,647.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,667,486.87	177,479,991.53
210201	Тэтгэврийн даатгал	78,765,526.28	123,448,063.09
210202	Тэтгэмжийн даатгал	8,949,532.64	14,644,028.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,405,225.69	10,503,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,925,136.81	2,625,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	16,622,065.45	26,258,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	115,412,322.80
210301	Гэрэл, цахилгаан	-	31,919,582.50
210302	Түлш, халаалт	-	76,177,740.30
210303	Цэвэр, бохир ус	-	7,315,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	887,055.00	73,512,246.28
210401	Бичиг хэрэг	-	2,536,150.00
210402	Тээвэр, шатахуун	887,055.00	54,725,410.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	3,687,699.36
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	7,957,210.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	4,605,776.42
2105	Нормативт зардал	-	488,181,354.72
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	438,077,924.72
210502	Хоол, хүнс	-	45,403,430.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	4,700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,089,000.00	23,394,082.80
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,830,000.00	14,718,800.00
210604	Урсгал засвар	259,000.00	8,675,282.80
2107	Томилолт, зочны зардал	7,134,150.00	2,700,000.00
210702	Дотоод албан томилолт	7,134,150.00	2,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	38,118,157.98
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	26,489,977.20
210803	Даатгалын үйлчилгээ	-	1,228,020.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	296,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	606,427.20
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	7,237,205.58
210807	Газрын төлбөр	-	62,528.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	2,197,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	386,980,291.13	27,294,399.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	386,980,291.13	26,414,899.64
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	879,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,600,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	88,600,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	88,600,000.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	4,018,072.33	18,860,951.47
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,013,600.00	17,820,000.00
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах	4,013,600.00	17,820,000.00
	Дотоод эх үүсвэрээр	4,013,600.00	17,820,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,013,600.00	17,820,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-4,013,600.00	-17,820,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	4,472.33	1,040,951.47
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,472.33
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,045,423.80

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	470,965,819.00	184,298,247.37	6,919,680,198.25	7,574,944,264.62
7	Тайлант үеийн үр дүн	-	-	38,120,507.30	38,120,507.30
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	470,965,819.00	184,298,247.37	6,957,800,705.55	7,613,064,771.92

11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	5,603,449.00	5,603,449.00
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-5,603,449.00	-	-5,603,449.00
17	Тайлант үеийн үр дүн	-	-	117,097,554.91	117,097,554.91
19	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	470,965,819.00	178,694,798.37	7,080,501,709.46	7,730,162,326.83

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,530,746,000.00	2,136,193,757.03	389,656,242.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,530,746,000.00	2,118,373,757.03	407,476,242.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,529,366,000.00	2,118,373,757.03	406,096,242.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,362,691,800.00	1,177,177,201.28	185,514,598.72
210101	Үндсэн цалин	772,453,000.00	651,155,823.93	121,297,176.07
210102	Нэмэгдэл	434,018,000.00	405,493,269.40	28,524,730.60
210103	Унаа хоолны хөнгөлөлт	47,817,000.00	15,380,460.28	32,436,539.72
210104	Урамшуулал	108,403,800.00	105,147,647.67	3,256,152.33
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	212,880,400.00	177,479,991.53	35,400,408.47
210201	Тэтгэврийн даатгал	160,363,200.00	123,448,063.09	36,915,136.91
210202	Тэтгэмжийн даатгал	13,129,300.00	14,644,028.44	-1,514,728.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,503,400.00	10,503,400.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	2,625,900.00	2,625,900.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	26,258,600.00	26,258,600.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	220,200,000.00	115,412,322.80	104,787,677.20
210301	Гэрэл, цахилгаан	52,800,000.00	31,919,582.50	20,880,417.50
210302	Түлш, халаалт	153,000,000.00	76,177,740.30	76,822,259.70
210303	Цэвэр, бохир ус	14,400,000.00	7,315,000.00	7,085,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	75,263,100.00	73,512,246.28	1,750,853.72
210401	Бичиг хэрэг	2,500,000.00	2,536,150.00	-36,150.00
210402	Тээвэр, шатахуун	54,847,800.00	54,725,410.00	122,390.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,205,300.00	3,687,699.36	-482,399.36
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,000,000.00	7,957,210.50	42,789.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,710,000.00	4,605,776.42	2,104,223.58
2105	Нормативт зардал	554,427,200.00	488,181,354.72	66,245,845.28
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,426,200.00	438,077,924.72	62,348,275.28
210502	Хоол, хүнс	41,250,000.00	45,403,430.00	-4,153,430.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,751,000.00	4,700,000.00	8,051,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,192,500.00	23,394,082.80	-2,201,582.80
210601	Багаж, техник, хэрэгсэл	16,143,500.00	14,718,800.00	1,424,700.00
210604	Урсгал засвар	5,049,000.00	8,675,282.80	-3,626,282.80
2107	Томилолт, зочны зардал	3,500,000.00	2,700,000.00	800,000.00
210702	Дотоод албан томилолт	3,500,000.00	2,700,000.00	800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,528,400.00	38,118,157.98	9,410,242.02
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,800,000.00	26,489,977.20	2,310,022.80
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	-	450,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,247,400.00	1,228,020.00	19,380.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	712,800.00	296,200.00	416,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,425,600.00	606,427.20	819,172.80
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,173,600.00	7,237,205.58	-63,605.58
210807	Газрын төлбөр	120,000.00	62,528.00	57,472.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	99,000.00	-	99,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,500,000.00	2,197,800.00	5,302,200.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,682,600.00	22,398,399.64	4,388,200.36
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,995,100.00	21,518,899.64	4,580,200.36
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	687,500.00	879,500.00	-192,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,380,000.00	-	1,380,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,380,000.00	-	1,380,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,380,000.00	-	1,380,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		17,820,000.00	-17,820,000.00
	Дотоод эх үүсвэрээр		17,820,000.00	-17,820,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,530,746,000.00	2,137,234,708.50	393,511,291.50
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,511,758,500.00	2,107,066,846.50	404,691,653.50
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		264,880.00	-264,880.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	2,511,758,500.00	2,106,801,966.50	404,956,533.50
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	18,987,500.00	30,167,862.00	-11,180,362.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,500,000.00	28,577,452.00	-13,077,452.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,487,500.00	1,590,410.00	1,897,090.00
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,472.33	-4,472.33
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,045,423.80	-1,045,423.80
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	
3	Төсвийн байгууллага	1	1	
5	АЖИЛЛАГСДЫН ТОО	88	88	
6	Удирдах ажилтан	1	1	
7	Гүйцэтгэх ажилтан	65	65	
8	Үйлчлэх ажилтан	22	22	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	4,896,000.00	4,896,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	4,896,000.00	4,896,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	4,896,000.00	4,896,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,896,000.00	4,896,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,896,000.00	4,896,000.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	4,896,000.00	-4,896,000.00
134	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	4,896,000.00	-4,896,000.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	4,896,000.00	-4,896,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд аймгийн Булган сумын нэгдсэн эмнэлэг нь их эмч 18, багийн эмч 4, эх баригч, сувилагч дунд мэргэжилтэн 32, аж ахуй 28 ажилтантайгаар баруун 3 сумын хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Эмнэлгийн тусламжийн алба, Захиргаа аж ахуйн алба, Амбулатори, Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн алба гэсэн 3 албатайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус эмнэлэг нь алслагдсан нутгийн хүн амд чанар аюулгүй байдлыг эрхэмлэн үйлчлүүлэгчид ээлтэй, хүртээмжтэй, эмнэлгийн тусламж үйлчилгээг чадварлаг багаар үзүүлэх зорилгын хүрээнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж иргэн төвтэй тусламж үйлчилгээ үзүүлэх, эх хүүхдийн ээлтэй тусламж үзүүлэх, байгууллагын соёлыг сайжруулж үйлчлүүлэгчдийн үйлчилгээ авах таатай орчин бүрдүүлэх зорилтуудыг дэвшүүлэн ажиллажээ.

Булган сумын нэгдсэн эмнэлэг нь үндсэн 7 тасагт 50 ортой үүнээс 2022 онд амбулаторийн үзлэг 29861, урьдчилан сэргийлэх үзлэг 1282, идэвхтэй хяналтыг 2199, гэрийн эргэлтийг 917, гэрийн дуудлага 1639 хүнд тус тус хийсэн байна. Түргэн тусламжийн 246 дуудлагад хүрч үйлчилснээс ойрын дуудлага-79, алсын дуудлага 167 байна. Эмнэлэгт 2017 хүн хэвтэн эмчлүүлж 16107 ор хоног ашигласан байна.

Эмнэлгээр үйлчлүүлж буй үйлчлүүлэгч нар өөрийн биеэр ирж цаг авч үйлчлүүлж байна. Цахимын ажилтны гар утсаар товлон цаг авч байгаа, цаашид байнгын ажиллагаатай суурин утастай болсон тул тогтмол утас ажиллуулахаар төлөвлөжээ. Эмнэлгийн удирдлагын тогтолцоо тогтворгүйгээс тайлант онд нягтлан бодогч 1 удаа, эм зүйч 2 удаа солигдсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь эрүүл мэндийн тухай, эрүүл мэндийн даатгалын тухай, эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай зэрэг хууль тогтоомжуудыг үйл хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд эрүүл мэндийн тухай хуульд 5 удаа, эрүүл мэндийн даатгалын тухай хуульд 2 удаа, эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд 1 удаагийн өөрчлөлт оржээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

2022 онд ТӨБЗГ-ын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Ховд аймгийн Булган сумын нэгдсэн эмнэлгийн даргын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний А/19 дүгээр тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгө бүртгэн авах, ашиглалтгүй хөрөнгийг данс бүртгэлээс хасуулах, хөрөнгийг картжуулах ажлуудыг зохион байгуулсан байна.

Мөн 2022 онд Ховд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийж, цалин хөлстэй холбоотой 10.2 сая төгрөгийн зөрчилд акт тогтоосон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн Булган сумын нэгдсэн эмнэлэг нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд аймгийн Булган сумын нэгдсэн эмнэлгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 108.9 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4.5	1,045.4	1,040.9
Авлага	194,282.1	11,963.8	-182,318.1
Бараа материал	271,967.1	305,313.6	33,346.5
Үндсэн хөрөнгө	7,392,786.8	7,431,744.9	38,958.2
Нийт хөрөнгө	7,859,040.4	7,750,067.9	-108,972.5
Өр төлбөр	245,975.6	19,905.6	-226,070.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	7,613,064.7	7,730,162.3	117,097.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7,859,040.4	7,750,067.9	-108,972.5

Дээрх хүснэгтээс харахад Ховд аймгийн Булган сумын нэгдсэн эмнэлгийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 108,972.5 мянган төгрөгөөр буурсны материаллаг нөлөө нь авлагын данстай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын сангаас 2,530.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,527.3 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 3.4 сая төгрөгийг олон улсын төсөл хөтөлбөрөөс бүрдүүлэхээр батлагдаж, гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 2,138.1 сая төгрөг, олон улсын төсөл хөтөлбөрөөс 3.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,141.1 сая төгрөг буюу 84.6 хувьтай байгаа нь эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүждэг болсонтой холбоотойгоор гүйцэтгэлийн санхүүжилтийг бүрэн авч чадаагүйтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Эмнэлгийн тусламж үйлчилгээ / үндсэн үйл ажиллагаа 71602/80101	2,494,883.4	2,106,506.6	388,376.8	84.4
2	Эмнэлгийн тусламж үйлчилгээ / нэг иргэнд ногдох нормативаар тооцсон зардал 71602/80302	30,995.1	30,786.1	209.0	99.3
3	Эмнэлгийн тусламж үйлчилгээ / ажил олгогчоос олгох тэтгэмж, дэмжлэг урамшуулал 71602/80802	1,380.0	805.0	575.0	58.3

4	Эмнэлгийн тусламж үйлчилгээ / олон улсын байгууллагаас 71602/83601	3,487.5	2,992.0	495.5	85.8
ДҮН		2,530,746.0	2,141,089.7	389,656.3	84.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар урьд оны санхүүжилтийн үлдэгдэл 4.9 сая төгрөг бүрдүүлж, үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Булган сумын нэгдсэн эмнэлгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Бадрал 2023 оны 01 дүгээр сарын 27-ноос 02 дүгээр сарын 02-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,060.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 41.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 32.9 сая төгрөгөөр тогтоосон байсныг гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт

зардлын 2,177.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 43.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 34.8 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Ховд аймгийн Булган сумын Нэгдсэн эмнэлэг нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

9 дүгээр зүйлд заасан албан томилолтын хувьд тус байгууллага нь 2022 онд 3.4 сая төгрөгийн томилолтын зардлыг 14 албан хаагчид олгосон байна. Энэ нь бага эмч нар Улаанбаатар хотод үзлэг, сургалтад, эмч, эмнэлгийн ажилтнууд суманд үзлэг оношилгоо хийх, Ховд аймагт сургалтад хамрагдах зэрэг ажлаар ажилласан байна.

8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцас, 11 дүгээр зүйлд заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмж, 12 дугаар зүйлд заасан бусад хангамжтай холбоотой зардал гараагүй байна.

13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалт, 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой ямар нэгэн зардал гараагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 32 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 127 байна.

Үндсэн дансаар 13.8 сая төгрөгөөр, тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулсан бөгөөд тендер зарлаагүйн улмаас шилэн дансны тухай хуулийн 6.4.3-д тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан; 6.4.4-д таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэрэг мэдээллүүдийг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

2022 оны 11 дүгээр сард завсрын аудит хийгдсэн бөгөөд аудитаар шатахууны тооцоог үнэн зөв бичих, тооцоог бодож акт үйлдэх, нүүрсний тооцоо бодох, эмийн тооцоо хийж тайланг үнэн зөв гаргах зэрэг зөвлөмжүүд өгөгдсөнийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Эмч мэргэжилтэнд 7 дугаар сард 2 дугаар улирлын мөнгөн урамшуулал олгохдоо нийгмийн даатгалын шимтгэлийг 3.7, ХХОАТ-ыг 2.8 сая төгрөгийг суутган тооцоогүй олгосон, мөнгөн урамшуулал олгохдоо илүү цагийн болон шөнийн нэмэгдэлд 1.6 сая төгрөгийг илүү тооцон олгосон, бараа материалын тайлан дахь хүнсний материалын зарлагын дүн сар, өдөр бүрээр бичсэн хоолны захиасны түүвэртэй тулгахад 9.5 сая төгрөгөөр зөрүүтэй, эмийн зарлагын түүвэр, санхүүгийн программ дах зарлагын түүвэр 6.8 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь санхүүгийн тайлан дахь тоон мэдээлэл бодитой үнэн илэрхийлснийг нотлох боломжгүй мөн хүнсний материал 13.9, аж ахуйн материал 1.3, эм ороох материал 3.7 сая төгрөгийн материалыг бодитой оршин байхгүй, өмнөх 2020 онд зарцуулаад зарцуулсан нь тодорхой бус байгаа нь дотоод хяналт хэрэгжүүлээгүй, үндсэн хөрөнгийн данс бүртгэлд байгаа хөрөнгүүд бодитоор оршин байгаа эсэх нь тодорхой бус сүүлийн жилүүдэд байгууллагын хөрөнгөд тооллого хийж тооцоо бодоогүй, ашиглалтын хугацаа дууссан ашиглагддаггүй 110.4 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлээгүй, томилолтын мөнгө олгохдоо анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, томилолтын хуудсыг байгууллагын удирдлагаар хаалт хийлгээгүй, ирсэн буцсан өдөр засвартай баримтаар 2.9 сая төгрөгийг олгосон, 2021 оны НДШ-ийн сар бүрийн тайлангийн цалингийн сан зөрүүтэй, ХХОАТ-ын тайлан дахь тоон мэдээлэл зөрүүтэй тайлагнасан зэрэг зөрчил илрүүлж 8.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 145.5 сая төгрөгийн албан шаардлага, 10.4 сая төгрөгийн зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт /мянган төгрөгөөр/		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	8.1	2	6.1	75.3
Албан шаардлага	1	145.5	1	145.5	100
Зөвлөмж	4	10.4	4	10.4	100
Нийт дүн	7	164.0	2	162.0	98.7

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Жолоочийн тооцоо бодолт, бараа материалын зарцуулалт, цалин олголт, эм, хүнсний тайлан зэрэг асуудлууд болон өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 28.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 28.7 сая төгрөгийн алдааг залруулав.

Үүнд: авлага, өглөгийг буруу илэрхийлсэн, хөрөнгө дутуу бүртгэсэн, үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг буруу илэрхийлсэн байна.

Аудитаар нийт 25.6 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 1.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 24.5 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

Тус байгууллагын урьд ажиллаж байсан дарга, нягтлан бодогчид холбогдох нүүрс, махтай холбоотой асуудал хуулийн байгууллагад шалгагдаж байна.

5.1 Залруулсан алдаа

Аудитаар шилэн дансны системд мэдээллийг дутуу байршуулсан, санхүүгийн тайланд авлага 4.0 сая төгрөгөөр дутуу, өглөг 0.3 сая төгрөгөөр илүү, үндсэн хөрөнгө 20.0 сая төгрөгөөр дутуу, нийт зардал 4.3 төгрөгөөр илүү тусгасан тул нийт 28.7 сая төгрөгийн алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.2-д “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна.” гэж заасны дагуу залруулав.

5.2 Төлбөрийн акт

2022 онд орон нутагт ажилласны нэмэгдэлд 30 хувиар тооцон 1.1 сая төгрөгийг илүү тооцон олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтад эмч 20 хувийн нэмэгдэл авахаар заасныг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоов.

5.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй болно.

5.4 Зөвлөмж

1. Шатахууны тооцоотой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Жолоочийн тооцоо түүвэрлэн шалгахад 3978 дугаартай автомашины 9 сарын тооцооны хуудсанд Баянгол багийн дуудлага, Үенч сумруу явсан замууд бичигдээгүй, алсын дуудлагын бүртгэлд Майхан гэх газарлуу явсан нь бүртгэгдээгүй зэрэг алдаатай холбоотой 0.2 сая төгрөгийн шатахуун зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна гэснийг, Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралтыг зургаадугаар зүйлийн 4 дахь хэсгийг, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалаар баталсан анхан шатны маягт хөтлөх заавар, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалыг мөрдөж ажиллах.

2. Тэтгэмжтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

2022 онд Тогооч Г.Ариунбилэг, үйлчлэгч Д.Зандан нарт нүүрс, түлээний хөнгөлөлтийг дотоод журмын дагуу олгохдоо тус бүрт 80 л АИ-92 бензинээр тооцон 0.5 сая төгрөгийн шатахуун олгосон нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж:

Түлшний хөнгөлөлт олгохдоо батлагдсан төсвийн дагуу төсвийн шууд захирагчийн тушаалын дагуу тэтгэмжийн зардлаас гаргах.

3. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Аудитаар 2022 оны 05 сарын 13-нд Метекс плас ХХК-д 13.87 сая төгрөг шилжүүлэн, Булган сумын ОНХС-аас 10.0 сая төгрөг шилжүүлж факс сервер тоног төхөөрөмж худалдан авахдаа тендер зарлаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөх, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримтлан худалдан авах ажиллагааг зохион байгуулах.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Авлага дутуу, өглөг илүү бүртгэсэн	1	4,384.2			1	4,384.2	1	4,384.2				
Хөрөнгө бүртгээгүй	1	20,000.0	1	20,000.0			1	20,000.0				
Зардал илүү тусгасан	1	4,384.2			1	4,384.2	1	4,384.2				
Дүн	4	28,768.4	1	20,000.0	2	8,768.4	3	28,768.4	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс	
		Тоо	Дүн

			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
АИ-92 түлшний олгосон.	1	472.0	0	0	0	0	1	472.0	0	0	0	0
Жолоочийн бодож хэмнэлтийг акт баталгаажуулаагүй байна.	1	177.0	0	0	0	0	1	177.0				
Тендер худалдан зарлаагүй авалт хийсэн	1	23,870.0	0	0	0	0	1	23,870.0	0	0	0	0
Эмчид орон нутгийн нэмэгдлийг 30 хувиар бодож олгосон	1	1,055.0	1	1,055.0	0	0						
Дүн	4	25,574.0	1	1,055.0	0	0	3	24,519.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил	0	0	0	0	0	0	0	0
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил	0	0	0	0	0	0	0	0
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	0	0	0	0	0	0	0	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: *[Signature]* **Х.БОЛДБААТАР**

АУДИТЫН МЕНЕЖЕР: *[Signature]* **А.ЦЭЦЭГСҮРЭН**

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР: *[Signature]*

Ц.БАДРАЛ